



Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК УБГД:000267784 Хувийн хэргийн дугаар:9012001021 ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	66110-Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	“Өлзийт экаунт аудит”ХХК
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	231,305,936 ширхэг
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	<i>Хянасан: Х.Эрдэнэбүрэн, Санхүүгийн ахлах мэргэжилтэн, Захиргаа Санхүүгийн газар</i>

1. *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

<i>Санхүүгийн байдлын</i>	Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
	ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хоронго		2,874,020,101.40	2,296,778,319.65
Эргэлтийн бус хоронго		2,504,553,658.08	23,184,922,418.26
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		5,378,573,759.48	25,481,700,737.91
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Бизнес хугацаат өр төлбөр		941,068,789.20	998,657,547.96
Урт хугацаат өр төлбөр		-	990,846,139.66
Эздийн өмчийн дүн		4,437,504,970.28	23,492,197,050.28
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		5,378,573,759.48	25,481,700,737.91

		Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
		Орлогын тайлан Үзүүлэлт		Борлуулалтын орлого (цэвэр)
		Борлуулалтын өртөг		
		Нийт ашиг (алдагдал)	5,501,624,362.55	4,241,344,850.62
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,352,735,578.87	769,747,808.20
		Орлогын татварын зардал	168,185,939.88	123,519,584.56
		Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,184,549,638.99	646,228,223.64
		Бусад дэлгэрэнгүй орлого		20,008,784,115.62
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		20,008,784,115.62
		Орлогын нийт дүн	3,184,549,638.99	20,655,012,339.26
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
		Өмч	23,130,593,600.00	23,130,593,600.00
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	20,021,146,332.29
		Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
		Хуримтлагдсан ашиг	(19,151,772,748.41)	(20,105,864,784.03)
		Нийт эздийн өмчийн дүн	4,437,504,983.28	23,492,197,059.28
Мөнгөн гүйлгээний тайлан		Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,272,456,273.35	(705,389,180.92)
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(97,682,445.84)	(423,392,511.67)
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	131,127,879.87
		Бүү цэвэр мөнгөн гүйлгээ	2,174,773,827.51	(997,653,812.73)
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	554,589,808.41	2,729,363,635.92
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл	2,729,363,635.92	1,731,709,823.19
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт			
	Өөрчлөлтгүй дүгнэлт			
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/			
<p><i>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</i></p>				

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл							
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table> <tr> <td>Нийт ашгийн хувь</td> <td>18%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>15%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>2.75%</td> </tr> </table>	Нийт ашгийн хувь	18%	Цэвэр ашгийн хувь	15%	Өөрийн хөрөнгийн өгөөж	2.75%
Нийт ашгийн хувь	18%							
Цэвэр ашгийн хувь	15%							
Өөрийн хөрөнгийн өгөөж	2.75%							
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>2.30</td> </tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td> <td>2.27</td> </tr> <tr> <td>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа</td> <td>0.085 -</td> </tr> </table>	Эргэлтийн харьцаа	2.30	Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.27	Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.085 -
Эргэлтийн харьцаа	2.30							
Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.27							
Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.085 -							
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2022 онд 183 хувьцаат компанийн хувьцаа, 21 компанийн өрийн хэрэгсэл, 2 хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 5 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааг идэвхтэй зохион байгуулан ажилласан. 2022-2023 онуудад системийн нөлөө бүхий арилжааны банкнууд болон төрийн өмчит компаниудын хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах ажлуудыг зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн Монголын Хөрөнгийн Бирж нь нүүрсний спот арилжааг 2023 оноос, уул уурхайн бусад түүхий эдэд суурилсан фьючерс гэрээг 2024 оноос эхлэн арилжаална.						
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.						
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.						
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/							
4.	Цалин урамшууллын мэдээлэл							

Тайлант онд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн гишдүүийн цалин урамшуулалд 82,760.0 сая төгрөг олгосон болно.

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн 2019-2021 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хугацаа дуусч, дараагийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2022-2024 онд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”- аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршилагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2022 онд гишүүн Д.Баянзул, Д.Энхбаатар, М.Санжаадорж, Л.Наранчимэг, А.Баттүрэв, Р.Гандиймаа, А.Анар нар улиран сонгогдсон бол С.Энхзориг, Б.Сүх-Очир нарыг чөлөөлж, С.Тулга, Ч.Дондогмаа нарыг шинээр томилсон байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2022 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2022 оны 11 дүгээр сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна.

Макро эдийн засгийн эрсдэл

Улс орны эдийн засгийн төлөв байдал нь санхүүгийн зах зээлтэй нягт хамааралтай, нөлөө бүхий хүчин зүйлд тооцогддог. Монгол Улс нь гадаад эдийн засгийн орчин, түүхий эдийн бүтээгдэхүүний үнээс хамаарсан мөчлөгийн савлагаа өндөртэй эдийн засагтай оронд тооцогддог. Макро эдийн засгийн гэнэтийн хүчин зүйлүүд болох шок, валютын хани, инфляцын түвшин, ажилгүйдэл, геополитиктой холбоотой хүчин зүйлүүдийн нөлөө нь бизнесийн ашигт ажиллагаа, иргэдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх боломжтой. Үүнийг дагаад хөрөнгийн зах зээлийн идэвхжил суларч, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Эдийн засагт томоохон нөлөө бүхий эрсдэлийн хүчин зүйлүүдийг дурдвал:

- ✓ Валютын ханшийн тогтворгүй байдал;
- ✓ Инфляц;
- ✓ Ажилгүйдлийн түвшин;
- ✓ Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эрэлт, нийлүүлэлт;
- ✓ Тосов, монгоний бодлого;

✓ Хил гаалийн хорио, хязгаарлалт зэрэг хүчин зүйлс байна.

Дээр дурдсан эдийн засгийн нөлөө бүхий эрсдэлийн хүчин зүйлүүдээс үүдэн бий болох боломжтой сөрөг нөлөөллийг боломжит хэмжээгээр бууруулахын тулд МХБ нь дотоод болон гадаад макро эдийн засгийн өөрчлөлт, төлөв байдал, санхүүгийн зах зээлийн чиг хандлагыг тогтмол ажиглах, судалгаа шинжилгээ хийх, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегиа эрсдэлийн хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэн шинэчлэн боловсруулж дагаж мөрдөх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ төрөлжүүлэн нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх арга хэлбэрээ боловсронгуй болгох зэрэг бодлогыг барьж энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Зах зээлийн эрсдэл

МХБ-ийн үйл ажиллагаанд тулгарч болох зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлст зээлийн хүүгийн эрсдэл, эрэлт нийлүүлэлтээс хамаарах үнэт цааснуудын ханшийн эрсдэл, валютын эрсдэл зэрэг зах зээлд үүсэж болох сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүдийн улмаас эрсдэл хүлээх ойлголтыг хамруулна.

Түүнчлэн, МХБ дээрх бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ болон хоёрдогч зах зээлийн арилжааны эрэлтэд нөлөөлж болох Үнэт цаас гаргагчаас хамааралгүй зах зээлийн олон хүчин зүйлүүд нь МХБ-ийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой. Зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдэд дор дурдсан асуудлуудыг хамруулан авч үзэх боломжтой юм.

- ✓ Томоохон санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын бодлого, стратегийн чиг хандлага;
- ✓ Үнэт цаасны зах зээл дэх санхүүгийн хэрэгслүүд, биржээс гадуурх бүтээгдэхүүн болон хөрөнгийн зах зээлийн бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлтийн нөлөөлөл;
- ✓ Үнэт цаас гаргагч, түүний гишүүн компаниудын зах зээлд арилжаа хийх, оролцогчдын нэвтрэх эрх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын менежментэд шууд болон шууд бусаар хязгаарлалт тавих (эсвэл үүнтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх) хууль тогтоомж, зохицуулалтын өөрчлөлтүүд;
- ✓ Эдийн засгийн хориг арга хэмжээ, эдийн засгийн бусад хязгаарлалтаас үүдэн зах зээлд нөлөө үзүүлэх.

МХБ нь дээрх эрсдэлийн хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг батлан, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй бөгөөд тус бодлогын баримт бичигт заасны дагуу зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэж болох эрсдэлийг хамгийн бага түвшинд тогтоох, эрсдэлийг удирдах, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ Сангийн яам 100%
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойш дуусах хуртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл байхгүй
9.	Ногдол ашигийн мэдээлэл ТӨБЗГ-т 1,592.2 сая төгрөгийн ноогдол ашиг төлсөн.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хамт олон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 24-р хороонд мод тарьж нэрэмжит төгөлтэй болсноос гадна байнга усалж тордож байна.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвнийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Х.АЛТАЙ

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.ЭРДЭНЭБҮРЭН

Албан тушаал: Санхүүгийн ахлах мэргэжилтэн

Гарын үсэг:

